# Авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан

2022.07.01 Хөвсгөл аймаг, Мөрөн сум

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГ. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД СУРТАЛЧЛАХ | | | | | | | | |
| 1 | | 1.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон | 2022 он | АТГ-аас бэлтгэсэн мэдээллийн төрөл, тоо: Мэдээллийг олон нийтэд хүргэсэн байдал а. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсан мэдээллийн төрөл, тоо: б. Албан ёсны цахим хуудсаар дамжуулсан мэдээллийн төрөл, тоо: в. Нийгмийн сүлжээгээр дамжуулсан мэдээллийн төрөл, | | - | Авлигатай тэмцэх газраас иргэдэд зориулан бүтээсэн богино хэмжээний видео, гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарын утасны сурталчилгааны шторк, богино долгионы радио (ФМ)-ийн зөвлөгөө мэдээлэл, авлигын эсрэг хууль сурталчилсан тараах материалуудыг Хөвсгөлийн өнгө сайт, Эрх чөлөө сонин, Мөрөн сумын Чингүнжавын талбайн лед дэлгэц, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк пэйж хуудсаар дамжуулан хүргэсэн.<br><br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг таниулах постор, шторк, видео контентыг давхардсан тоогоор 1200 иргэнд хүргэх ажлыг зохион байгуулав. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нийгмийн сүлжээ (facebook, twitter, youtube), лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх | | тоо: г. Сурталчилгааны самбарт байршуулсан мэдээллийн төрөл, тоо: д. Бусад хэлбэрээр дамжуулсан мэдээллийн төрөл, тоо: | | | | |
| 2 | | 1.2. АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах | 2022 он | АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээний тоо: Зохион байгуулсан арга хэмжээний тоо а. Байгууллагын түвшинд: б. Салбарын хэмжээнд: в. Орон нутгийн хэмжээнд: | | - | 1. Авлигатай тэмцэх газрын ажлын хэсэг 2022 оны 04 дүгээр сард Хөвсгөл аймагт ажиллахтай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс тус ажлын хэсгийн гишүүдтэй хамтран зарим төрийн байгууллагын албан хаагчдад “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” талаарх сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн 28, Мэргэжлийн хяналтын газрын 23, агентлаг байгууллагуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах, хянах эрх бүхий албан тушаалтан 35, Нийгмийн даатгалын хэлтсийн 21 албан хаагч танхимаар, сумдын Нийгмийн даатгалын 23 байцаагч цахимаар тус тус оролцлоо.<br><br>2. Авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх зорилгоор “Зөв зөвд шударга зөв” аяныг Авлигатай тэмцэх газраас улсын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжээнд эхлүүлэн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж байгаа юм. Аяны хүрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс төрийн байгууллагуудад үе шаттай зохион байгуулж байна. Тухайлбал, - 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 19 албан хаагчид, - 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Татварын хэлтсийн 23 албан хаагчид, - 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын албан хаагч, 23 сум 1 тосгоны газрын даамал нийт 43 албан хаагчид, - 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр аймгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон Эмнэлэг хяналтын комиссийн 12 гишүүнд, - 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтсийн 57 албан хаагчдад тус тус зохион байгуулав. Дээрх сургалтын мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын фэйсбүүк пэйж хуудас, "АТГ-Олон нийтийн төв" фэйсбүүк пэйж хуудсанд байршуулан ажиллаж байна. | |
| 3 | | 1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах | 2022 он | "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" самбарт байршуулсан мэдээллийн төрөл, | | Орон нутгийн төсөв-1 сая төгрөг | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран "Шударга ёсны хөгжил дэвшилд" 5 мэдээллийн самбарыг аймгийн Засаг даргын Тамгын газар, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах | | тоо: | | | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймгийн Нэгдсэн эмнэлэгт тус бүр байршуулав. | |
| ХОЁР. АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, АЛБАН ХААГЧДЫГ СУРГАЛТАД ХАМРУУЛАХ | | | | | | | | |
| 4 | | 2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлэх | 2022 он | Сургалтын хөтөлбөрийн тоо: Хамрагдах ТАХ-ийн тоо: | | - | Өмнөх онуудад авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг Авлигатай тэмцэх газарт хүргүүлдэг байсан бөгөөд энэ онд сургалтын захиалгыг нэгдсэн байдлаар хүргүүлээгүй байна. Сургалтын хэрэгцээ, шаардлагыг харгалзан тухай бүрт аймаг хариуцсан Авлигатай тэмцэх газрын комиссартай холбогдож, сургалтыг авч байна. | 70% |
| 5 | | 2.2. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан шатны сургалтад албан хаагчдаа хамруулах | 2022 он | Анхан шатны сургалтын хөтөлбөрийн тоо: Хамрагдах ТАХ-ийн тоо: | | - | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т заасан "Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах" зорилтын хүрээнд төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсан. Тус сургалтад аймгийн Засаг даргын Тамгын газар болон харьяа агентлагуудад шинээр томилогдсон албан хаагчид оролцсон | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | | 2.3. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг давтан сургалтад албан хаагчдаа хамруулах | 2022 он | Давтан сургалтын хөтөлбөрийн тоо: Хамрагдах ТАХ-ийн тоо: | | - | Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг давтан сургалтыг 21 аймаг, сумдын албан тушаалтнуудад 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр цахимаар зохион байгуулсан бөгөөд тус сургалтад алба хаагчдыг идэвхитэй хамруулсан. 2018 оны 03 сараас 2022 оны 03 сарыг хүртэлх хугацаанд давтан сургалтад хамрагдсан албан хаагчдын мэдээллийг гаргав. | 100% |
| 7 | | 2.4. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц боломж, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх | 2022 он | Зохион байгуулсан арга хэмжээний тоо: Хамрагдах хүүхэд залуус, иргэдийн тоо: | | - | 1. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг “Сургагч багш” бэлтгэх сургалтад 2022 онд Хөвсгөл аймгаас 3 албан хаагч хамрагдаж, сургагч багшаар бэлтгэгдсэн. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс сургагч багш нартай хамтран авлигын ойлголт, илрэх хэлбэр, авлигын хор уршиг, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замын талаарх сургалтыг Ерөнхий боловсролын “Ирээдүй цогцолбор”, “Сод эрдэм”, “Эрдмийн далай”, “Дэлгэрмөрөн” цогцолбор сургуулийн 500 орчим сурагчдын дунд зохион байгууллаа.<br><br>2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албатай хамтран Төрийн болон хууль хяналтын байгууллага, үйлчилгээний салбарын хамтарсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр “Авлигын эсрэг миний-бидний оролцоо” арга хэмжээг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Авлигатай тэмцэх газраас | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зарласан “Зөв зөвд шударга зөв” аянд нийт 18 байгууллагын 90 гаруй төрийн албан хаагчид нэгдлээ. | |
| ГУРАВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС ГАРГАСАН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ | | | | | | | | |
| 8 | | 3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх | 2022 он | Зөвлөмжийн тоо: Зөвлөмжид тусгагдсан арга хэмжээний тоо: Хэрэгжилтийн хувь: | | - | 2021, 2022 онд Авлигатай тэмцэх газраас тухайлсан зөвлөмж ирүүлээгүй бөгөөд 2019, 2020 онд ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн тухайн үед зөвлөмжөөр ирүүлсэн аймгийн төсөв санхүү, шилэн данс, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, худалдан авах ажиллагааны журмын талаарх асуудлыг үйл ажиллагаандаа тусгаж, зөрчил дутагдлыг дахин гаргахгүй байхад анхаарч ажиллаа. | Үнэлэх боломжгүй |
| 9 | | 3.2. Мөрдөгчийн мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 2022 он | Мөрдөгчийн мэдэгдлийн тоо: Мэдэгдэлд тусгагдсан арга хэмжээний тоо: Хэрэгжилтийн хувь: | | - | 2021 онд ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, тайлан мэдээг мэдэгдэлд заасан хугацаанд гаргаж хүргүүлсэн. 2022 оны эхний хагас жилд мөрдөгчийн мэдэгдэл ирээгүй байна. | 100% |
| 10 | | 3.3. Зөрчил арилгуулах албан бичигт тусгагдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 2022 он | Албан бичгийн тоо: Албан бичигт тусгагдсан арга хэмжээний тоо: Хэрэгжилтийн хувь: | | - | Авлигатай тэмцэх газрын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05/414 тоот "Хуулийн хэрэгжилт хангуулж, хариуцлага тооцуулах тухай" албан бичгээр Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг дарга Б.Батбаяр нь албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар бусдад давуу байдал олгосон, бусдын хууль бус үйлдлийг хуулийн байгууллагад нэн даруй мэдээлэх үүргээ биелүүлээгүй байгаа талаар дурдаад Хөвсгөл аймгийн Засаг дарга | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Ш.Идэрбаясгаланг бүрэн эрхийнхээ хүрээнд Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн дээрх асуудлыг шийдвэрлэж, эргэж хариу мэдэгдэх чиглэлийг өгсөн. Тус албан бичигт дурдсан асуудлыг судлан үзэж, Хөвсгөл аймгийн Засаг даргаас Мөрөн сумын Засаг даргад сахилгын шийтгэл ногдуулж энэ талаарх хариу мэдэгдсэн албан бичгийг Авлигатай тэмцэх газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хүргүүлсэн байна. | |
| ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЭРМЭЛЗЭЛ, САНААЧИЛГА ӨРНҮҮЛЭХ | | | | | | | | |
| 11 | | 4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах | 2022 он | Хандсан байгууллага, иргэдийн тоо: Гаргасан саналын тоо: Дэмжсэн байгууллага, иргэдийн тоо: Дэмжсэн саналын тоо: | | “Хөгжлийн шийдэл” ТББ-ын төсөв-1.3 сая төгрөг | 1. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай байгуулж буй батламж гэрээ, агентлаг байгууллагуудын дарга нартай байгуулж буй хамтран ажиллах болон үр дүнгийн гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг тусгаж оруулсан бөгөөд хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тооцож хэвшсэн.<br><br>2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс “Хөгжлийн шийдэл” ТББ-ын хэрэгжүүлж буй “BEST” хөтөлбөртэй хамтран “Төрийн албан хаагчдын авлига, ашиг сонирхлын эрсдэлийг бууруулах нь” сэдэвт сургалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад жижиг дунд бизнес эрхлэгчдийн төлөөлөл, тэдний төртэй ажиллах харилцаанд хамтран ажилладаг төрийн байгууллагын албан хаагчид оролцож, харилцан мэдээлэл солилцож, санал сэтгэгдлээ | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуваалцлаа. | |
| 12 | | 4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ, хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах | 2022 он | Гэрээ, хэлэлцээрийн тоо: Тусгасан заалтын тоо: | | - | Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулах "Үр дүнгийн гэрээ", агентлаг байгууллагын дарга нартай байгуулах "Хамтран ажиллах гэрээ"-нд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудлыг нэг зорилт болгон оруулсан бөгөөд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд:<br>1. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж зөрчил гаргаагүй байх<br>2. ХАСУМ хянуулж томилгоо хийх, хуульд заасан тохиолдол бүрт мэдэгдэл, тайлбар гаргаж бүртгүүлсэн байх<br>3. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлж ажилласан байх<br>4. Шинээр томилогдсон нийтийн албан тушаалтнуудыг томилогдсоноос хойш 30 хоногт хөрөнгө орлогын мэдүүлэг гаргуулж хэвшсэн байх 5. Авлигын эсрэг олон улсын өдрийг сум орон нутагтаа иргэд, олон нийт, төрийн албан хаагчдын оролцоог хангаж сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байх Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр үнэлж хэвшсэн. | 100% |
| ТАВ. АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮСГЭХ ШАЛТГААН НӨХЦӨЛИЙГ АРИЛГУУЛАХ | | | | | | | | |
| 13 | | 5.1. Авлигын эрсдэл ба | 2022 он | Цахим хэлбэрт шилжүүлсэн | | - | Авлигын эрсдэл ба авлига гарах нөхцөлийг бууруулах, төрийн байгууллагын | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | авлига гарах нөхцөлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх / төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м / | | төрийн үйлчилгээний тоо: Үйлчилгээний стандарт шинээр нэвтрүүлсэн, шинэчилсэн тоо: Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулсан тоо: (хууль, дүрэм, журам шинэчлэх замаар) Эрсдэлийг бүртгэдэг, үнэлдэг эсэх | | | үйлчилгээг иргэнд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, үйлчилгээний шат дамжлагыг багасгах зорилгоор аймгийн хэмжээнд энэ оны 3 дугаар улиралд багтаан "Үйлчилгээгээ хялбаршууль" аяныг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Тус аяны бэлтгэл болгож энэ оны 1, 2 дугаар улиралд аймгийн хэмжээнд иргэдийн хамгийн их үйлчлүүлдэг төрийн байгууллага, тэдгээрийн үйлчилгээний хүртээмжийн талаар судалгааг гаргалаа. Судалгаагаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Нэгдсэн эмнэлгээр хамгийн их иргэн үйлчлүүлдэг бөгөөд хамгийн их хүнд сурталтай байгууллага гэж тодорхойлогдсон байна. Дээрх байгууллагын албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх сургалтыг зохион байгуулж, аяны талаар танилцуулга, мэдээллийг хүргэлээ. Цаашид "Үйлчилгээгээ хялбаршууль" аяны удирдамжийг агентлаг, байгууллагуудад хүргүүлэн, үр дүнг дүгнэж, үйлчилгээгээ сайжруулсан байгууллагыг урамшуулж, үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем болох "ERP" системийг аймгийн бүх төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа ашиглаж, төрийн үйлчилгээний шат дамжлага бүхий л түвшинд буурч байна. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗУРГАА. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ | | | | | | | | |
| 14 | | 6.1. Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4, Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан заалтуудын хэрэгжилтийг хангаж ажиллах | 2022 он | а. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 – 6.1.6 заасан мэдээллүүдийг тогтоосон хугацаанд иж бүрэн тайлагнасан эсэх б. Шилэн дансны тухай хуулийн 6.4.1 – 6.4.9 заасан мэдээллүүдийг 7 хоногийн дотор иж бүрэн тайлагнасан эсэх в. Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.9-т заасан мэдээллүүдийг тогтоосон хугацаанд иж бүрэн тайлагнасан эсэх | | - | Аймгийн хэмжээнд 25 төсвийн ерөнхийлөн захирагч, улс, орон нутгийн төсвийн 211 байгууллага, 19 орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани, 3 төрийн өмчит хувьцаат компани, 170 аж ахуйн нэгж нийт 428 байгууллага шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд оруулж хэвшээд байна. Хөвсгөл аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2022 онд шилэн дансны системд 7-20 төрлийн мэдээллийг хагас жил, улирал, сар бүр, тухай бүр гэсэн давтамжтайгаар жилийн турш 151 хүртэлх удаа 100 хувийн гүйцэтгэлтэй оруулж төсөв, санхүүгийн ил тод байдлыг бүрэн хангаж ажилалаа. Шилэн дансны тухай хуулийн 6.1.1 – 6.1.6.д заасан Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор, дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр гаргаж, хуулийн хугацаанд тайлагнасан. Хөвсгөл аймгийн сайт болох www.khovsgol.gov.mn сайтад Шилэн дансны тухай хуулийн 6.4.1 – 6.4.9.д заасан мэдээллийг байршуулж, төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Авлигын эсрэг хуулийн 6.1.4-д төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх гэж заасан бөгөөд тус мэдээллийг www.khovsgol.gov.mn сайтад байршуулсан байна. | |

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР